



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 16

Арвайхээр

Г

Г

Хөтөлбөр шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "д", 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.1.3, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх "Архидалтгүй Өвөрхангай" шинэчилсэн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэр, байгууллагадаа зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, Хэлтэс албадын дарга нарт даалгасугай.
3. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн үндсэн чиглэл, орон нутгийн төсөвт тусгах замаар санхүүжүүлж ажиллахыг аймаг, сумдын Засаг дарга нарт, хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д даалгасугай.

ДАРГА

А.ИШДОРЖ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2018 оны 08 сарын 25-ний өдрийн
16. дугаар тогтоолын хавсралт

“АРХИДАЛТГҮЙ ӨВӨРХАНГАЙ” ХӨТӨЛБӨР

ИЮА0019

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн гэмт хэргийн болон хэв журмын нөхцөл, хүн амын эрүүл мэндийн байдалд үндэслэн боловсруулав. Үүнд:

Аймгийн хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг сүүлийн жилд буурсан үзүүлэлттэй байгаа хэдий ч хүний амийг санаатай хохиросон гэмт хэргийн 100.0 хувь, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн 27.7 хувь, золгүй байдлаар нас барагт болон амшиг хорлосон хэргийн 12.0 гаруй хувь нь тус тус согтуугаар үйлдэгджээ.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн 61.6 хувь нь гэр бүл, ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа нь гэр булийн хүчирхийллийн үндсэн шалтгаан болж, хүүхэд, эмэгтэйчүүдийн эрүүл аюулгүй орчинд тайван амьдрах нөхцөл бололцоог алдагдуулж, хүүхэд өсвөр үеийн сэтгэл зүй, оюун санаа, хүмүүжил төлөвшилд сөргөөр нөлөөлж байна.

Архины шалтгаант эмгэг өөрчлөлт, архинд донтох өвчтэй буюу байнга хэтрүүлэн хэрэглэж удаа дараа эрүүлжигдсэн иргэдийн тоо тогтмол буурахгүй байгаа нь архинд донтох өвчнийг эрт илрүүлэх, эмчлэн эдгэрүүлэх, эмчлэгдсэн иргэнийг нийгэмшүүлэх, зорилтот бүлэгт чиглэсэн дэмжих үйлчилгээг хөгжүүлэх, эрчимжүүлж ажиллах шаардлагатай байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар олон нийтийн дунд архины хэрэглээ өндөр байгаа нь тогтоогдсон бөгөөд байгууллага хамт олноороо зохион байгуулалттай, нийтийг хамарсан үралдаан тэмцээн, аливаа арга хэмжээний үеэр согтууруулах ундаа хэрэглэх нөхцөл бололцоог бүрдүүлэх, ажлын байр, албан томилолтоор ажиллаж байхдаа согтууруулах ундаа хэрэглэх зэрэг зохисгүй хэв маягаас татгалзах шаардлагатай байна.

Архинд донтох өвчтэй болон архидан согтуурч байгаа иргэдийн дийлэнх нь идэвхтэй хөдөлмөрийн насны иргэд байгаа нь аймгийн хөгжил дэвшилд сөрөг нөлөө үзүүлж, ажилгүйдэл, ядуурлын үндсэн шалтгаан нь архидан согтуурах явдлаас болж

байна. Иймд энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг үргэлжлүүлэн, шинэ зорилт арга хэмжээг тодорхойлж архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа

2.1. Зорилго

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, олон нийтэд архидан согтуурахтай тэмцэх, таслан зогсоох, сургалт, мэдээллийг идэвхижүүлэх замаар иргэдийн согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, архидан согтуурснаас хүн амын эрүүл мэнд, нийгэмд учрах сөрөг үр дагаврыг багасгах орчинг бүрдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Зорилт

2.2.1."Архидалтгүй-Өвөрхангай" хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг эрчимжүүлж, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын архидан согтуурахтай тэмцэх ажилд оролцох оролцооны үр нөлөөг дээшлүүлэх, идэвхижүүлэх, албан хаагчдыг хариуцлагажуулах

2.2.2. Архинд донтох өвчнийг эмчлэн эдгэрүүлэх үйлчилгээг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотой зохион байгуулах, архины хамаарлаас гарсан, эмчлэгдэж, эрүүлжүүлэгдсэн иргэдийг ажлын байраар хангах, дэмжих үйлчилгээг хөгжүүлэх

2.3. Хөтөлбөрийн хугацаа

Хөтөлбөрийг 2018-2020 дуустал хэрэгжүүлнэ.

Гурав. Удирдлага зохион байгуулалт

3.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Бүсийн Оношилгоо, эмчилгээний төв, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хариуцан эрхэлнэ. Сумын Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллана.

3.2 "Архидалтгүй Өвөрхангай" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай шийдвэр, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх

3.3. Сум, байгууллагын үйл ажиллагааг дүгнэхдээ архидан согтуурахаас сэргийлэх талаар хийсэн ажил, түүний үр дүнг шалгуур үзүүлэлт болгон үнэлж байх

3.4 Хөтөлбөрт тусгагдсан зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн төрийн байгууллага нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд заагдсан хугацаанд хэрэгжилтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст ирүүлнэ.

3.5 Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд хөтөлбөрийн үр дүнг нэгтгэн дүгнэж аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнана.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилтот хүрэх үйл ажиллагааны чиглэлүүд

4.1. Нэгдүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

4.1.1 Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчилан таниулах, соён гэгээрүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх

4.1.2 Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэсэн иргэнийг нэвтрүүлэхгүй байх, ажлын байранд болон албан томилолтоор ажиллах хугацаандаа архидан согтуурч, сахилгын зөрчил гаргасан ажилтан, албан хаагчдад хариуцлага тооцож ажиллах

4.1.3 Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрэм, хөдөлмөрийн гэрээнд ажлын байран дээр архи, согтууруулах ундаа хэрэглэсэн сахилгын зөрчил гаргавал оногдуулах хариуцлагыг тодорхой тусган төрийн албан хаагчийн үүрэг хариуцлага, сахилга батыг өндөржүүлэх

4.1.4. Архидалтын эсрэг үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшил, аж ахуйн нэгж, баг, хороо, сум, байгууллага, иргэн, АА бүлгийг шалгаруулан урамшуулж, нийтэд сурталчлах

4.2 Хоёрдугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

4.2.1. Сургалт, эмчилгээнд хамрагдаж архинаас гарсан иргэдийг Мэргэжил сургалт үйлдэрлэлийн төв болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн материаллаг баазад түшиглэн мэргэжил олгох сургалтанд хамруулж, нийгмийн халамжийн болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

4.2.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт ажил олгогчоос ирүүлсэн ажлын байрны захиалгын дагуу архинаас гарсан иргэдийг ажилд зуучлах, хөнгөлттэй зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамруулах

4.2.3. Аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн Сэтгэц, Наркологийн тасгийн үйл ажиллагаа, тохижилт үйлчилгээг сайжруулж, наркологийн эмч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч мэргэжлийн боловсон хүчнээр хангах ажлыг шийдвэрлэх

4.2.4. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хамтарсан багийг дэмжиж, тохиолдол бүр дээр холбогдох этгээдийг эрүүлжүүлэх, эмчлэх, соён гэгээрүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд татан оролцуулах

4.2.5. Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллага, АА бүлэг, Мэргэжлийн баг, Аддиктологийн багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах

4.2.6. Архинд донтох эмгэгтэй иргэдийн албадан эмчилгээнд хамруулах үйл ажиллагаанд гарах зардлыг төсөвт тусган жилд 20-оос доошгүй иргэнийг хамруулах

**Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх Төрийн болон төрийн бус
байгууллагуудын үүрэг, оролцоо**

5.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс:

5.1.1. Архидан согтуурахтай тэмцэх хууль, тогтоомж, хөтөлбөр, захирамжийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд хангах талаар төрийн захиргааны байгууллагын үндсэн үйл ажиллагааг чиглүүлж, удирдлага зохицуулалт, зохион байгуулалтын арга хэмжээ авах

5.1.2. Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр төрийн байгууллага, ажилтнуудын баримтлах зарчим, эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх

5.1.3. Архины хамааралтай иргэдийг сургалт, эмчилгээнд хамруулах удирдлага зохион байгуулалтыг хангах

5.1.4. Архины хамаарал бүхий иргэдийн хандлагыг өөрчлөх, архины хамаарлаас ангижрах, эрүүл зөв амьдрах чиглэлээр лекц, сургалт, уулзалт ярилцлага зэрэг соён гэгээрүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах

5.1.5. Архины хамаарлаас ангижрах хүсэлтээ гаргасан иргэдийг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын сургалт, сайн дурын эмчилгээнд хамруулах

5.1.6. Архины хэт хамааралтай иргэдийг холбогдох байгууллагын саналыг үндэслэн албадан эмчилгээнд хамруулах /Төв аймгийн Баян суманд байрлах ШШГЕГазрын харьяа албадан эмчлэх төвийн эмчилгээнд хамруулах/

5.1.7. Аливаа баяр ёслол, тэмдэглэлт өдрүүдийг архигүй тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалыг бататгах, залуучууд чөлөөт цагаа зүй зохистой боловсон өнгөрүүлэх тааламжтай орчинг бурдүүлэн ажиллах талаар төрийн болон төрийн бус байгууллагуудыг чиглүүлэх

5.1.8. Төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлагын түвшинд “Архидалтгүй Өвөрхангай” хөтөлбөрийг танилцуулах, ажлын байрны захиалганд архины хамаарлаас гарсан болон архины албадан эмчилгээнд хамрагдсан иргэдийг нэн тэргүүнд ажилд зуучлах талаар зөвлөлдөх уулзалт зохион байгуулах

5.1.9. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгүүдэд хяналт тавих талаар гарсан журмыг боловсронгуй болгох, мөрдүүлэх талаар арга хэмжэээ авч ажиллах

5.2. Боловсрол, соёл урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар:

5.2.1. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад архины хор уршгийн талаар зөв зан үйлийг эзэмшиүүлэхэд чиглэсэн лекц, сургалт, уулзалт ярилцлага зэрэг соён гэгээрүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах

5.3. Цагдаагийн газар:

5.3.1. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах, архидалтаас үүдэн гарсан гэмт хэрэг, зөрчлийн байдалд дүн шинжилгээ хийж хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хэсгийг мэдээллээр хангах

5.3.2. Архи хэтрүүлэн хэрэглэгч, архинд донтох өвчтэй иргэдийн судалгааг гарган, албадан эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах

5.3.3. Архидан согтуурсаны улмаас гэмт хэрэг, зөрчилд удаа дараа холбогдсон иргэдийн судалгааг гаргаж, гэр бүл, хамт олонтой нь, холбогдох байгууллагуудтай хамтран хамтарч ажиллах

5.3.4. Согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ажуйн нэгжийн үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийх, зөвлөгөө өгөх

5.4. Мэргэжлийн хяналтын газар:

5.4.1. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр гарсан бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих

5.4.2. Согтууруулах ундааны тээвэрлэлт, хадгалалтын технологи, стандарт, чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хянан холбогдох арга хэмжээг авч байх

5.4.3. Согтууруулах ундаа худалдан борлуулдаг, үйлчилгээ үзүүлдэг, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх

5.4.4. Архины хамааралтай этгээдэд хууль эрх зүй, эмнэлэгийн тусlamж үзүүлж буй байгууллагын эрүүл ахуйн нөхцөл, эмчилгээний чанарыг сайжруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих

5.5. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар:

5.5.1. Сургалтанд хамрагдаж архины хамаарлаас гарсан болон албадан эмчилгээнд хамрагдсан иргэдийг гагнуурчин, мужаан, сийлбэрч, барилгын засал чимэглэлч, сантехникч, жолооч гэх мэт нийтлэг мэргэжил олгох сургалтанд хамруулан дэмжлэг үзүүлэх

5.5.2. Мэргэжил олгох сургалтуудыг аймгийн МСҮТөв, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн материаллаг бааз суурь дээр түшиглэн оновчтой зохион байгуулах

5.5.3. Архины хамааралаас ангижрах сургалт, албадан эмчилгээнд хамрагдсан иргэдийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэхэд дэмжлэг үзүүлж хөнгөлттэй зээл олгох, тоног төхөөрөмжөөр хангах иргэдийг сургаж мэргэшүүлэх хөдөлмөрийн зохицуулалт хийх

5.5.4. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт ажил олгогчоос ирүүлсэн ажлын байрны захиалгын дагуу сургалтанд хамрагдаж архины хамаарлаас ангижирсан иргэдийг ажилд зуучлах, хөнгөлттэй зээл тусlamж, төсөл хөтөлбөрт хамруулах

5.5.5. Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн ажлын байрны судалгааг жил бүр нэгтгэн гаргах, аймгийн Засаг даргын Хууль, эрх зүйн хэлтэст тайлагнах

5.5.6. Орон гэргүй тэнэмэл, архины хамаарлаас гаргах сургалт, албадан эмчилгээнд хамрагдсан иргэдийг орон гэртэй болгох хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөвт суулгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

5.6. Эрүүл мэндийн газар, Бүсийн оношлогоо эмчилгээний төв:

5.6.1. Наркологийн тасгийн үйл ажиллааг тогтмолжуулж, тусlamж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх

5.6.2. Архинд донтох өвчнийг эрүүл мэндийн суурь тусlamжийн хүрээнд эрт илрүүлэх, эмчлэгдсэн хүнийг хяналтанд авах арга хэмжээг зохион байгуулах

5.6.3. Согтууруулах ундааны хор нөлөө, архинд донтох өвчний талаар хүүхэд, залуучууд, нийт хүн амын дунд явуулах эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, арга зүйн зөвлөгөө өгч ажиллах

5.6.4. Архинд донтох өвчнийг эрт илрүүлэх, эмчлэх, нөхөн сэргээх талаар эмч, сэтгэл засалч, нийгмийн ажилтанг сургах, туршлага судлуулах, тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх

5.6.5. Аймгийн ИТХТэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан Мэргэжлийн баг, сумдын Адиттологийн багийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах

5.6.6. Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн Наркологийн тасгийг өргөжүүлэх, сэтгэл заслын болон сургалтын өрөөг тохижуулахад дэмжлэг үзүүлэх

5.6.7. Архинд донтох өвчний үед үзүүлж буй эмчилгээний үр дүнг сайжруулах хүрээнд зайшгүй шаардлагатай эмийн жагсаалтанд орсон сэтгэц нөлөөт болон архины дуршил бууруулах шинэ эмээр хангах

5.6.8. Архинд донтох өвчинг эрт илрүүлэх, эмчлэх, урьдчилан сэргийлэх талаар аргачлал, удирдамж боловсруулан эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлэгийн ажилтнуудад сургалт явуулах

5.7. Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар:

5.7.1. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэн орон нутгийн онцлог, тулгамдсан асуудалд тулгуурлан төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих

5.7.2. Архи хэрэглэхгүй байх зөв дадлыг бий болгох, аливаа баяр ёслол, тэмдэглэлт үйл явдлыг архигүй тэмдэглэн өнгөрүүлэх талаар уриалга гаргах

5.7.3. Архины хамаарлаас ангижрах сургалт, албадан эмчилгээнд хамрагдсан иргэдийг сүм хөгжүүлэх сангаас олгож буй хөнгөлттэй зээлэнд хамруулах, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж хөнгөлттэй зээл олгох, тоног төхөөрөмжөөр хангах, иргэдийг сургаж мэргэшүүлэх, хөдөлмөрийн зохицуулалт хийх

5.7.4. Архи хэрэглэдэггүй иргэдийн туршлага, зөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг тогтмолжуулах, тэдний оролцоотойгоор архидан

согтуурахаас сэргийлэх олон нийтийн байгууллага байгуулж ажиллах үүсгэл санаачлагыг бүх талаар дэмжих

5.7.5. Архинд донтох өвчтэй иргэдийг сайн дураар хаяггүй эмчилгээнд хамруулах, зайлшгүй шаардлагатай тохиолдолд албадан эмчлэх ажлыг зохион байгуулах, архинаас гарах эмчилгээ хийлгэсэн иргэдийн ахуй амьдралд туслах, ажлын байраар хангах

5.7.6. Архидан согтуурахаас сэргийлэх талаар тодорхой ажил зохион байгуулан үр дүнд хүрсэн байгууллага, хамт олонд дэмжлэг үзүүлэх, тэдний үйл ажиллагааг сурталчлах урамшуулах

5.7.7. Төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дүгнэхдээ архидан согтуурахаас сэргийлэх талаар хийсэн ажил, түүний үр дүнг нэг үзүүлэлт болгон сайн ажилласан байгууллага хамт олныг дэмжин урамшуулах

5.8. Хэвлэл мэдээллийн байгууллага:

5.8.1. Архидан согтуурснаас нийгэм, эдийн засаг, хувь хүн ёс зүй, бие сэтгэлд учрах хор уршгийн талаар нийт ард иргэд, ялангуяа хүүхэд өсвөр үеийнхэнд тодорхой дэс дараатай мэдлэг, хандлага, зөв зан үйлийг эзэмшиүүлэхэд чиглэсэн мэдээ мэдээлэл, суртал ухуулгыг нийтлэх, цагийг нэмэгдүүлэх

5.8.2. Хүний эрүүл мэндэд хортой согтууруулах ундааны хэрэглээг дэмжих борлуулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зар сурталчилгааг радио телевизээр нэвтрүүлэхгүй, хэвлэл /сонин сэтгүүл/-д нийтлэхгүй, санамж, зурагт хуудас, гудамжны самбараар сурталчлахгүй байх

5.8.3. Архидалтгүй Өвөрхангай хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиож буй ажлын ололт, архины хамаарлаас ангижирсан иргэдийг олон нийтэд тухай бүрт нь сурталчилж, мэдээллэж байх

5.9 Төрийн бус байгууллага:

5.9.1 Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны чиглэлийг хэрэгжүүлэхэд өөрсдийн зүгээс идэвхитэй оролцох, бусад байгууллагуудтай хамтран үр ашигтай ажиллах талаар идэвхи санаачлага гаргах, хамтран ажиллах

5.10 Аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллагууд:

5.10.1. Нийгмийн хариуцлагын хүрээнд “Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх сан”-д архи согтууруулах ундаа худалдан борлуулсан ашгийн тодорхой хувийг төвлөрүүлэх, мэргэжлийн дадлага, сургалтанд хамрагдсан ажил идэвхитэй хайж байгаа иргэдийг ажлын байраар хангах

5.10.2. Ажлын байраар хангаж ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг урамшуулах, хөнгөлттэй зээл тусламж, төсөл хөтөлбөрт эхний ээлжинд хамруулах

5.10.3. "Архигүй орчин, архидалтгүй хамт олон" уриан дор аливаа баяр ёслол, тэмдэглэлт өдрийг архигүй тэмдэглэх, архины хор хөнөөлийн талаар сургалт зохион байгуулах, ажилтнуудаа хамруулах, аян зохион байгуулах.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр нь олон улсын төсөл хөтөлбөр, улсын болон орон нутгийн төсвийн дэмжлэгээс бүрдэнэ.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, төлөвлөж Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн

7.1. Олон нийт архины хор хөнөөлийн талаарх мэдлэгтэй болж, олон нийтийн дунд эрүүл зөв амьдрах хандлага нэмэгдсэн байна.

7.2. Архинд донтох өвчлөл буурч, эмчлэн эдгэрүүлсэн архины асуудлаа шийдвэрлэж өөрчлөгдсөн иргэдийн тоо жил тутам өссөн байна.

7.3. Архидан согтуурсан гэмт хэрэг зөрчлийн гаралт буурч, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл сайжирсан байна.

Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхдээ архины хамааралтай иргэдийн судалгаа тэдэнд үйлчилгээ үзүүлсэн байдлыг суурь үзүүлэлт болгон ашиглах бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн		
		2018	2019	2020
Зорилт 1.	Архидалтгүй-Өвөрхангай хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг эрчимжүүлж, төрийн болон төрийн бус байгууллага, ААН-ийн архидан согтуурахтай тэмцэх ажилд оролцох оролцооны үр нөлөөг дээшлүүлэх, идэвхижүүлэх, албан хаагчдыг хариуцлагажуулах			
1.1.	Ажлын байран дээр архи, согтууруулах ундаа хэрэглэсэн сахилгын зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцож ажилладаг байгууллагын эзлэх хувь	40%	70%	100%

1.2	Архидан согтуурхаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд чиглэсэн төрийн болон ТББ, баг, АА бүлгийн тоо нэмэгдсэн байдал	30%	40%	50%
Зорилт 2. Архинд донтох өвчнийг эмчлэн эдгэрүүлэх үйлчилгээг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотой зохион байгуулах, архины хамаарлаас гарсан, эмчлэгдэж, эрүүлжүүлэгдсэн иргэдийг ажлын байраар хангах, дэмжих үйлчилгээг хөгжүүлэх				
2.1	Архины хамааралтай иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн өсөлт	20%	40%	50%
2.2	Сургалт, эмчилгээнд хамрагдаж архины хамаарлаас гарсан иргэдийг хөдөлмөр, халамжийн чиглэлээр дэмжих үйлчилгээний үзүүлэлт /архины хамааралтай иргэдийг мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамруулсан, байнгын болон түр ажлын байран зуучилсан байдал/	30%	40%	50%

-Оо-